

ЗӨВШӨӨРӨВ:  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



БАТЛАВ:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА



УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧИЙН  
“МОНГОЛ ЭМ СУДЛАЛ”-ЫН  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Мэргэшлийн индекс: S(r) 091708  
Сургалтын хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ  
2022 он

#### **БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

Б.Цэрэнцоо	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн Уламжлалт жор судлалын тэнхимийн эрхлэгч, Уламжлалт анагаах ухааны тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны доктор, дэд профессор
Ж.Байгалмаа	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн Уламжлалт жор судлалын тэнхимийн багш, БУ-ны доктор, дэд профессор
Ц.Мөнхтуяа	Шинэ анагаах ухаан их сургуулийн Анагаах ухааны сургуулийн захирал, АУ-ны доктор, дэд профессор
Л.Батгэрэл	Монголын үндэсний их сургуулийн Уламжлалт анагаах ухааны хөтөлбөрийн багийн ахлагч, АУ-ны доктор, дэд профессор
Б.Саранчимэг	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн эмийн үйлдвэрийн дарга, эм зүйч, АУ-ны доктор
Н.Мөнхбат	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн төгсөлтийн дараах сургалтын албаны эмнэлзүйн сургагч багш, Уламжлалт анагаах ухааны хүний их эмч, АУ-ны магистр
Б.Аюушжав	Оточ Манрамба их сургуулийн Уламжлалт анагаах ухааны тэнхимийн багш, Уламжлалт анагаах ухааны хүний их эмч, АУ-ны магистр
А.Мягмаржав	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн төгсөлтийн дараах сургалтын албаны эмнэлзүйн сургагч багш, УАУ-ны тэргүүлэх зэргийн эмч
Ц.Жавхланбаатар	Тэжээхүйн ухаан ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн, “Заан хуж” эмнэлгийн ерөнхий эмч, УАУ-ны их эмч

#### **ХЯНАСАН:**

П.Эрхэмбаяр	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр
Б.Туяа	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр
М.Оюунчимэг	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын Уламжлалт анагаах ухааны хэлтсийн Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн  
33 дугаар тогтоолоор зөвшөөрөв.

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧИЙН “МОНГОЛ ЭМ СУДЛАЛ”  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгийн байгууллагад ажиллаж буй уламжлалт анагаах ухааны их эмч нарын мэдлэг, чадвар, хандлагыг шинжлэх ухааны хөгжил, нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн төгсөлтийн дараах сургалтаар тасралтгүй дээшлүүлэх нь чухал юм. Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар Уламжлалт анагаах ухааны их эмч 1142 ажиллаж, нийт эмч нарын 11.1%-ийг эзэлж байна.

Эдүгээ дэлхийн анагаах ухааны хөгжлийн чиг хандлага, Монгол хүний өвчлөл, нас баралт, тархалтын судалгаанаас үзэхэд уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, уламжлалт анагаах ухаанаар төрөлжсөн нарийн мэргэжлийн мэргэшсэн эмч бэлтгэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор урган гарч байна. Монгол эм судлал нь өвчнийг анагаах 4 ерөндгийн нэг болох бөгөөд уламжлалт анагаах ухааны үндсэн онол болох хий, шар, бадган, одон зурхайн 5 махбодын онол дээр тулгуурлаж, эмийн амт, амт дагалдсан найман чадал, хүч, эрдмийг баримтлан, өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчлэх зорилгоор уламжлалт эмийн эмчилгээний аргуудаар эмчилж, эдгээр эмийн хэлбэрүүдийг гардан хийх мэдлэг, ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх нь чухал юм.

Иймд “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/445 дугаар тушаалаар Уламжлалт анагаах ухааны чиглэлийн найман үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс батлагдсан нь төгсөлтийн дараах сургалтад томоохон дэвшил болж, сургалт явагдах эрхзүйн орчин бүрдсэнээр энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Энэхүү хөтөлбөр нь уламжлалт анагаах ухааны чиглэлээр их, дээд сургуулийг бакалаврын зэрэгтэй хүний их эмчийн мэргэжлээр төгссөн, Монгол эм судлал үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдаж буй резидент эмч нарт зориулагдана.

**ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО**

Уламжлалт анагаах ухааны чиглэлээр хүн амд эмнэлгийн анхан шатны чанартай тусламж үзүүлж, зонхилон тохиолдох өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж эрүүлжүүлэх, өвчин эмгэгийг оношлох, эмчлэх онолын мэдлэг, ур чадвар, дадал, хандлагыг эзэмшсэн уламжлалт анагаах ухааны мэргэжлийн эмчийн түвшинд эрүүл мэндийн бүх шатлалын эмнэлэгт бие даан ажиллах

чадвартай Уламжлалт анагаах ухааны эмч (Doctor of traditional medicine) бэлтгэхэд оршино.

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

**“Монгол эм судлал”-ын сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:**

Хүн амыг уламжлалт анагаах ухаанаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон; зонхилон тохиолдох өвчний эмийн эмчилгээ хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн; эмчлүүлэгчид энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг уламжлалт анагаахын эмч байна.

### ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна:

1. *Монгол эм судлаач их эмч байх (Doctor of Traditional Mongolian Medicine Pharmacist)*
2. *Мэргэжлийн байх (Professional)*
3. *Тасралтгүй суралцагч байх (Continous Learner)*
4. *Харилцагч байх (Communicator)*
5. *Хамтрагч байх (Collaborator)*
6. *Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байх (Community Health Advocate)*
7. *Зохион байгуулагч, манлайлагч байх (Leader)*

Энэхүү цогц чадамж нь **Монгол эм судлалын** эмчийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, хандлагын тухай ойлголт юм. Үүнд:

#### 1. **Монгол эм судлаач эмч байх (Doctor of Traditional Mongolian Medicine Pharmacist):**

УАУ-ны чиглэлээр төгсөлтийн дараах сургалтад суралцагч оюутанд уламжлалт эмийн түүхий эдийг таних, түүхий эдэд агуулагдах бодис, хандлагдах бодис зэргийг тодорхойлж сурах, жорыг задлан шинжлэх, эмд орж буй эмийн түүхий эдүүдийн амт, чадал, үйлдэл, хэрэглэх аргыг эзэмшүүлнэ.

- 1) Монгол орны эмийн ургамлын тархац, нөөцийг зөв үнэлэх, зохистой хэрэглэх
- 2) Уламжлалт эмэнд ордог эмийн түүхий эдүүд, тэдгээрийг хэрэглэх хэсгүүдийн амт, чадал, үйлдэл, агуулагдах бодисуудын тухай
- 3) Өвчний мөн чанартай уялдуулж уламжлалт аргаар эм найруулах
- 4) Эмд орж буй эмийн түүхий эдүүдийн амт, чадал, үйлдэл, агуулагдах бодис
- 5) Эмийн түүхий эдийн номхотгол, эмийн үйлдэл, хэрэглэх заалтыг тайлбарлаж сурах

## **2. Мэргэжлийн байх (*Professionalism*):**

- Монголын уламжлалт анагаах ухааны онол ойлголтод багтсан өвчнүүдийг оношлох асуумж, бодит үзлэгийн аргуудыг эзэмшиж, өвчнийг зөв оношлох, ялган оношлох, оношийн үндэслэл гаргах;
- Эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, идээ ундаа, явдал мөр, эм, засал, нэгдмэл эмчилгээний болон урьдчилан сэргийлэх аргуудыг оновчтой сонгох;
- Уламжлалт анагаах ухаан, нэгдмэл анагаах ухааны эмийн эмчилгээний арга техникийг өндөр түвшинд хийж гүйцэтгэх, эмчлүүлэгчид зааж сургах, зөвлөх;
- Анагаах ухааны бусад мэргэжилтнүүдтэй баг болон хамтран ажиллах, нарийн мэргэжилтний оношилгоо, эмчилгээг үнэлж дүгнэх;
- Эмчлүүлэгчид биеийн байдал болон эмчилгээнийх нь талаар зөв, ойлгомжтой тайлбарлах.

## **3. Суралцагч байх (*Learner*):**

- Мэдлэг, чадвараа байнга дээшлүүлэх хүсэл, эрмэлзэлтэй байх, цагийг үр бүтээлтэй ашиглах;
- Олон төрлийн мэдээллийн эх үүсвэрээс суралцах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- Богино хугацааны хэрэгцээт сургалтуудад хамрагдах;
- Хамтран суралцагч болон эмнэлгийн бусад мэргэжилтнүүдтэй харилцан мэдлэг, чадвараа хуваалцах, тэдгээрт сургалт хийх замаар суралцах.

## **4. Харилцагч (*Communicator*):**

- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах;
- Үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглах;
- Шаардлагатай тохиолдолд эмчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх.

## **5. Хамтрагч (*Collaborator*):**

- Тухайн орон нутгийн уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцох, хамтран ажиллах;
- Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдтэй мэдлэг, чадвараа хуваалцан хамтран ажиллах;
- Эмч, үйлчлүүлэгчийн хамтын ажиллагааг бэхжүүлж, эмчилгээ үйлчилгээг үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх.

## **6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community health advisor*):**

- Хүн амд эрүүл мэндээ сахин хамгаалахад туслах сургалт сурталчилгаа явуулах, зөвлөгөө өгөх;
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Үйлчлүүлэгчийн удирдан чиглүүлэгч, үлгэр дуурайлал болох.

## **7. Зохион байгуулагч, манлайлагч (Leader):**

- Уламжлалт анагаах ухаанаар дамжуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг нэмэгдүүлж, жигд хүртээх;
- Эмнэл зүйн харилцаанд ёс зүйн хэв хэмжээг мөрдөж, хууль тогтоомжид нийцсэн харилцаа хандлагыг төлөвшүүлэх;
- Өвчний эдгэрэлтийг хурдасгах бүх боломжийг дайчлан ажиллах;
- Нотолгоотой, аюулгүй байдлыг хангасан тусламж үйлчилгээг үзүүлэхэд анхаарах.

## **ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ**

### **5.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил**

- Эмнэлгүүдтэй сургалт эрхлэх байгууллагын сүлжээ үүсгэн хамтран ажиллана.
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг үндсэн болон бусад сүлжээ сургалт эрхлэх эмнэлгүүдийн тасгийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг эмнэлэг болон бусад сүлжээ сургалт эрхлэх эмнэлгүүдийн УАУ-ны тасаг, эмийн үйлдвэрүүд, лабораториуд боловсруулна.
- Сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтад заавал хамрагдана.

### **5.2. Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, суурь мэдлэг, өвчин, гардан үйлдэл**

Сургалтын агуулгын хүрээнд Монгол эм судлал үндсэн мэргэшлээр суралцаж байгаа эмч нь сургалтын төгсгөлд орон нутагт ганцаараа бие даан тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амбулаториор ирэх өвчтөн, хэвтэн эмчлүүлэгсдийн УАУ-ны оношилгоо, эмийн эмчилгээг хариуцан ажиллах явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, үндсэн мэргэшлийн сургалтад оролцоно.

#### **5.2.1. Өвчний шинж тэмдэг (signs and symptoms) (аль ч тойролтод тохиолдох):**

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношилгоо хийн, анхан шатны эмчилгээ, уламжлалт анагаахын тусламж үйлчилгээг үзүүлж чаддаг болох:

1. Халууралт (Fever)
2. Шарлалт (Jaundice)
3. Толгой өвдөлт (Headache)
4. Ухаан алдалт, балралт (Altered level of consciousness)
5. Таталт (Seizure)

6. Ханиалгалт, цэр гаралт (*Coughing, Excretion sputum*)
7. Цээжээр өвдөлт (*Chest pain*)
8. Дотор муухайралт, бөөлжилт, хоосноор огиулах (*Nausea, Vomiting*)
9. Хэвлийн өвдөлт (*Stomachache*)
10. Суулгалт (*Diarrhea*)
11. Нуруугаар өвдөлт (*Back pain*)
12. Мөчдийн саажилт (*Paralysis*)
13. Хаван /цайвар, усан, суваг хаван/ (*Edema*)
14. Үений өвдөлт (*Arthralgia*)
15. Зүрх зогсолт (*Cardiac arrest*)
16. Жихүүцэх (*Shivering*)
17. Эвшээх, суниах (*Yawning, Stretching*)
18. Таван мэдрэхүй үл тодрох (*dullness of the sense organs*)
19. Сэтгэл санаа тогтворгүй болох (*Mental instability*)
20. Сүүж бэлхүүс, яс үесээр хатгуулж өвдөх (*Stabbing pain in the hips, waist, bones and joints*)
21. Энд тэндгүй тогтворгүй өвдөх (*Shifting pain*)
22. Идээ шингэсний дараа, өглөө үүрээр, үдшийн бүрийд өвчин хөдлөх (*Arising after digestion, in the evening and around dawn*)
23. Аманд гашуун амт амтагдах (*Bitter taste in the mouth*)
24. Идээ шингэх үед өвдөх (*Pain during digestion*)
25. Хоолонд дургүй болох (*Loss of appetite*)

#### **5.2.2. Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд:**

##### **Гурван гэм, хурмал өвчний эмийн эмчилгээ**

1. Хийн өвчин (A00-A03)
2. Шарын өвчин (TMB00- TMB02)
3. Бадганы өвчин (TMC00- TMC03)
4. Хурмал борын өвчин (TMD00- TMD04)

##### **Дотор өвчний эмийн эмчилгээ**

5. Эс шингэх өвчин (TME00)
6. Бэтэг (TME01)
7. Цайвар хаван (TME02)
8. Суваг хаван (TME03)
9. Усан хаван (TME04)
10. Хорхойн өвчин (TME05)
11. Өтгөн хаагдах (TME06)
12. Шээс хаагдах (TME07)
13. Шижин (TME08)
14. Зүрхний өвчин (TMK00)
15. Уушгины өвчин (TMK01)
16. Элэгний өвчин (TMK02)
17. Дэлүүний өвчин (TMK03)
18. Бөөрний өвчин (TMK04)
19. Ходоодны өвчин (TMK05)

20. Нарийн гэдэсний өвчин (ТМК06)

21. Бүдүүн гэдэсний өвчин (ТМК07)

22. Цэсний өвчин (ТМК08)

**Халуун өвчний эмийн эмчилгээ (ТМF00- 100)**

23. Халуун, хүйтний хэрэгт товчоон (ТМF00)

24. Уул талын завсрын халуун (ТМF01)

25. Эс боловсорсон халуун (ТМG00)

26. Дэлгэрсэн халуун (ТМG01)

27. Хоосорсон халуун (ТМG02)

28. Нуугдсан халуун (ТМG03)

29. Хуучин халуун (ТМG04)

30. Булингартсан халуун (ТМG05)

31. Гэмтсэн халуун (ТМН00)

32. Хямарсан халуун (ТМН01)

33. Халдварт халуун (ТМН02)

**Эмэгтэйчүүдийн өвчний эмийн эмчилгээ**

34. Эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчин

35. Эмэгтэйчүүдийн цус бүрэлдсэн өвчин

**Ад донгийн өвчний эмийн эмчилгээ**

36. Махбодын адыг анагаах

37. Солио өвчнийг анагаах

38. Саа (гараг ад) өвчин

**Хорын өвчний эмийн эмчилгээ**

39. Найруулсан хорыг засах

40. Урвасан хорыг засах

41. Бодитой (мөн чанарын) хорыг анагаах

**Лаборатори**

42. Лабораторийн шинжилгээ

43. Зүрхний цахилгаан бичлэг, Дотор өвчин судлал

44. Хэт авиан оношилгоо (ЭХО)

45. Гэрлийн шинжилгээ (Рентген)

**Яаралтай тусламж судлал:**

46. Толгой, хүзүү, нурууны гэмтэл (суурь тусламж, тээвэрлэлт)

47. Түлэгдэл, хөлдөлт

48. Амьсгалын замд гадны биетээр бөглөрөх, живэх

49. Ясны хугарал

50. Тархинд цус харвах (цочмог үеийн)

51. Зүрхний дутагдал, зүрхний шигдээс (цочмог үеийн)

52. Шок, Ком

53. Хүчил шүлтийн тэнцвэр алдагдал

54. Цочмог хордлого

55. Могой, шавжид хатгуулах (хачиг)



### 5.2.3. Гардан үйлдлийн жагсаалт:

#### 1. Эмийн ургамлын түүхий эдийг таних, чанарын болон тоон шинжилгээ хийх

1. Уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэгддэг эмийн ургамлыг түүх, хатаах, цэвэрлэх, савлах, хаяглах, тээвэрлэх, ангилах, эмд хэрэглэгдэх хэсгийг ангилан ялгах /харласан, шарласан, гэх мэт/
2. Эмийн ургамлын түүхий эдийн навчийг шинжилгээнд бэлтгэж, гадаад бүтцийг тодорхойлох
3. Эмийн ургамлын түүхий эдийн ишийг шинжилгээнд бэлтгэж, гадаад бүтцийг тодорхойлох
4. Эмийн ургамлын түүхий эдийн цэцгийг шинжилгээнд бэлтгэж, гадаад бүтцийг тодорхойлох
5. Эмийн ургамлын түүхий эдийн үр жимсийг шинжилгээнд бэлтгэж, гадаад бүтцийг тодорхойлох
6. Эмийн ургамлын газрын дээд хэсгийн анатомийн бүтцийг тодорхойлж, оношлох шинжээр нь ялгах
7. Эмийн ургамлын газрын доод хэсгийг шинжилгээнд бэлтгэж, гадаад, дотоод бүтцийг тогтоох
8. Эмийн ургамлын амьдралын хэлбэр, зарим зүйл ургамлын овог, төрөл, зүйлээр нэрлэж таних
9. Нүцгэн үрт болон бүрхүүл үрт ургамлын ялгааг илрүүлэх
10. Нэг үрийн ба 2 үрийн талт ургамлын ялгааг илрүүлэх
11. Эмийн ургамлын тархалт, нөмрөгжилт, нөөц, анагаах ухаанд хэрэглэж байсан талаар мэдээллийн эх сурвалжид хайлт хийх
12. Ургамлын түүхий эдэд нөлөөлөх гадаад орчны хүчин зүйлийг үнэлэх
13. Ургамлын түүхий эдийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, экологийн боловсрол эзэмших
14. Эмийн ургамлыг хамгаалах, тарималжуулах

#### 2. Эмийн ургамлаас биологийн идэвхт нэгдлийг хандлах, ялгах

1. Монгол оронд өргөн хэрэглэгддэг эмийн ургамлын түүхий эдэд чанар, тооны шинжилгээ явуулж, дүгнэлт гаргах
2. Анхдагч, хоёрдогч нийлэгжлийн бодис, үйлчлэгч ба дагалдагч бодисыг тодорхойлох
3. Биологийн идэвхт нэгдэл (гликозид, зүрхний гликозид, сапонин, фенолт нэгдэл, кумарин, ксантон, аргаах бодис, эфирийн тос, өөх тос, витамин, алкалоид)-ийг түүхий эдэд таньж тодорхойлох, шинжлэх
4. Биологийн идэвхт нэгдэл, хортой эмийн ургамал, алкалоидтой ажиллах үед баримтлах аюулгүй ажиллагаа, лабораторийн дүрэм журмыг сахиж мөрдөх

3. Амьтны гаралтай эмийн түүхий эдийг таних, ялгах, эмийн жорд бэлтгэх зорилгоор хатаах, хуурах, шарах номхотголын аргууд
4. Эрдсийн гаралтай эмийн түүхий эдийг таних, ялгах, эмийн жорд бэлтгэх зорилгоор хатаах, хуурах, шарах, шатаах, дэвтээх номхотголын аргууд
5. МУАУ-ны жор судлалын гардан үйлдэл
  1. Эмд орж буй эмийн түүхий эдүүдийн амт, чадал, үйлдэл, агуулагдах бодисыг тайлбарлаж сурах
  2. Эмийн жорыг задлан шинжлэх
  3. Өвчний мөн чанартай уялдуулж уламжлалт аргаар эм найруулах
  4. Уламжлалт эмд хөлөг, хачир хийх ёсыг эзэмших
  5. Уламжлалт эмийн номхотгол хийх чадвар эзэмших
  6. Уламжлалт эмийн үйлдэл, эм уух ёс, хэрэглэх заалтыг тайлбарлаж сурах
  7. Эмчилгээний зарчмыг зөв сонгох
6. Амирлуулах эмийн хэлбэрийг бэлтгэх гардан үйлдлүүд
  1. Уламжлалт тан эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  2. Уламжлалт талх эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  3. Уламжлалт үрэл эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  4. Уламжлалт тосон эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  5. Уламжлалт зуурмал эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  6. Уламжлалт үнсэн эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  7. Уламжлалт хандан эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  8. Уламжлалт архин эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  9. Уламжлалт өвсөн эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  10. Уламжлалт эрдэнийн эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
7. Арилгах эмийн хэлбэрийг бэлтгэх гардан үйлдлүүд
  1. Уламжлалт тосон засалд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  2. Уламжлалт туулганд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  3. Уламжлалт бөөлжүүлэгт орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
  4. Уламжлалт хамрын эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах

5. Уламжлалт зөөлөн шимтэд хэрэглэгдэх эмд орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
6. Уламжлалт нирухад орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах
7. Уламжлалт судлын туулгад орох эмийн түүхий эдийг зөв тодорхойлж, эм найруулах уламжлалт аргуудаар найруулж сурах

#### **8. Эмнэл зүйн жор судлалын гардан үйлдлүүд**

1. Монгол эмийн эмчилгээний зарчим, үндсэн 6 өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ, судлагдсан байдал
2. Их архаг өвчин болох хаван, бэтэг, эс шингэсэн өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ
3. Таван цулын өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ
4. Зургаан сав эрхтний өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ
5. Халуун өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ
6. Мэдрэлийн өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ
7. Эмэгтэйчүүдийн өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ
8. Хүүхдийн өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ
9. Хамт төрсөн найман яр шарх, хэсэг бусаг өвчнийг анагаах жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ
10. Хүчжүүлэх, шимжүүлэх жор найрлага, тэдгээрийн заалт, хэрэглээ

#### **9. МУАУ-ны эмийн номхотголын гардан үйлдлүүд**

1. Уламжлалт эмийн түүхий эдийг номхотгох зарчмыг баримтлан /задгай болон битүү шатаах, шаргаах, хайлуулах, нурамлах/ аргаар номхотгох
2. Шингэн биетийг ашиглан номхотгох арга /тунгаах, дэвтээх/
3. Галыг ашиглан номхотгох арга /задгай болон битүү шатаах, шаргаах, хайлуулах, нурамлах
4. Гал ба шингэнийг ашиглан номхотгох арга /чанах, жигнэх/
5. Тан, талх эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах
6. Үрэл, зуурмал, тосон эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах
7. Үнсэн, өвсөн эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах
8. Хандан, архин эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах
9. Эрдэнийн эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах

### **ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА**

- Сургалт нийт 88 долоо хоног үргэлжлэх ба эхний жил 44 тойролт, хоёрдох жил 44 тойролт нийт 88 тойролтуудыг хийж гүйцэтгэсэн байна.
- МАУ-ны онол, эмнэлгийн төвөд хэл, эмийн ургамал судлал, фитохими, ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эд, монголын уламжлалт анагаах ухааны жор судлал, монголын уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эдийн номхотгол, уламжлалт эмийн технологи, эмнэл зүйн жор судлал, гурван гэм, дотор өвчин, халуун өвчин, мэдрэлийн өвчин,

эмэгтэйчүүд, хүүхэд, хамт төрсөн найман яр, хэсэг бусаг өвчин, хүчжүүлэх, шимжүүлэх эмийн эмчилгээ, эмнэлгийн эрх зүй, харилцааны ур чадвар, халдварын сэргийлэлт, хяналт, амилуулах суурь тусламж гэсэн 18 тойролтоор явуулна.

- Сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, стандарт, заавар, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтад заавал хамрагдана.
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. 1 улирал нь 22 долоо хоног үргэлжилнэ. Сургалтын хугацаанд резидент нь жилд 1 сар амарна.

### Тойролтын хуваарь

№	Тойролтын нэр	Хугацаа /7 хоног/
<b>Эхний жилд: 44 долоо хоног 44 тойролт</b>		
1	МУАУ-ны онол	4
2	Эмнэлгийн төвөд хэл	2
3	Эмийн ургамал судлал, фитохими	6
4	Ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эд судлал	8
5	Монголын уламжлалт анагаах ухааны жор судлал	8
6	Уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эдийн номхотгол	8
7	Уламжлалт эмийн технологи	8
<b>Хоёрдох жилд: 44 долоо хоног 44 тойролт</b>		
1	Амилуулах суурь тусламж	4
2	Эмнэл зүйн жор судлал	10
3	Гурван гэмийг анагаах эмийн эмчилгээ	4
4	Дотор өвчний эмийн эмчилгээ	6
5	Халуун, мэдрэлийн өвчний эмийн эмчилгээ	8
6	Эмэгтэйчүүд, хүүхдийн өвчний эмийн эмчилгээ	8
7	Хамт төрсөн найман яр шарх, хэсэг бусаг өвчний эмийн эмчилгээ	2
8	Хүчжүүлэх, шимжүүлэх эмийн эмчилгээ	2
	<b>Нийт</b>	<b>88</b>

## **ТОЙРОЛТ 1. МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ОНОЛ**

### **(4 долоо хоног)**

1. УА-ны хөгжлийн түүхэн үе шатууд, “Анагаах ухааны дөрвөн үндэс” (АУДҮ) зохиолын агуулга, бүтэц 4 үндэс (жүд), 11 орон (най), 15 үес (гав), 4 товч (доши) хэмээх ухагдахуун
2. УА-ны тулгуур онолууд болох арга билгийн онол, таван махбодын онол, цул сав эрхтний онол, махбодын бэлгэ чанар, мөн чанар
3. Биеийн ба өвчний билгэ чанар, эрүүл ба өвчтэй биеийн мөн чанар
4. Өвчний шалтгаан, нөхцөл, орох ёс, өвчин явагдах үе шат
5. Өдөр бүрийн хийгээд цаг, ахуй үесийн явдал мөрийн тухай, өвчингүй эрүүл орших ёс
6. Дөрвөн ерөндгийн тухай ойлголт /идээ ундаа, явдал мөр, эм, засал/
7. Хөврөл тогтох бойжих ёс, долоон тамир тунгалаг цөвийн боловсролт
8. Биеийн гүйцэд хэмжээ
9. Биеийн үйл ялгал, өвөрмөц чанар

## **ТОЙРОЛТ 2. ЭМНЭЛГИЙН ТӨВӨД ХЭЛ (2 долоо хоног)**

1. Төвд хэлний цагаан толгойн дан, давхар үсгүүд
2. угтвар дагавар
3. тийн ялгал
4. тооны нэр
5. өвчний ангилал
6. түүхий эд жорын нэршил зэргийг уншиж, бичиж сурах

## **ТОЙРОЛТ 3. ЭМИЙН УРГАМАЛ СУДЛАЛ, ФИТОХИМИ (6 долоо хоног)**

1. Эмд орж буй эмийн түүхий эдийн хэсгийг зөв таних
2. эмийн түүхий эдүүдийн нэршлийг (латин, төвд, монгол) нэрлэх
3. эмийн түүхий эдүүдийн үйлдэл үйлчилгээг зөв сонгох
4. түүхий эдэд агуулагдах бодисыг мэддэг байх
5. ховордож буй ургамлын таримжуулалт хийх аргад суралцах,
6. өвчтөнд эмийн үйлчилгээ болон хэрэглэх аргыг зөв таних
7. Эмийн ургамлыг түүх хугацаа
8. Эмийн ургамлыг түүсний дараа хадгалах
9. Хамгаалах горимыг зөв тооцож сурах
10. Ургамал, экологийн хууль эрх зүйн баримт бичгүүдийг судлах

## **ТОЙРОЛТ 4. УРГАМАЛ, АМЬТАН, ЭРДСИЙН ГАРАЛТАЙ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД**

### **(8 долоо хоног)**

1. Эмд орж буй эмийн түүхий эдийн хэсгийг зөв таних
2. эмийн түүхий эдүүдийн нэршлийг (латин, төвд, монгол) нэрлэх
3. эмийн түүхий эдүүдийн үйлдэл үйлчилгээг зөв сонгох
4. түүхий эдэд агуулагдах бодисыг мэддэг байх
5. ховордож буй ургамлын таримжуулалт хийх аргад суралцах
6. өвчтөнд эмийн үйлчилгээ болон хэрэглэх аргыг зөв таниулах
7. Эмийн ургамлыг түүх хугацаа

8. Эмийн ургамлыг түүсний дараа хадгалах
9. хамгаалах горимыг зөв тооцож сурах
10. Ургамал, амьтан, эрдсийн экологийн хууль эрх зүйн баримт бичгүүдийг судлах

#### **ТОЙРОЛТ 5. МУАУ-НЫ ЭМИЙН ЖОР СУДЛАЛ (8 долоо хоног)**

1. Уламжлалт аргаар эм найруулах
2. Жорыг задлан шинжлэх
3. Эмд хөлөг, хачир хийх ёс
4. Амирлуулан үйлдэх эмийн хэлбэр
5. Арилган үйлдэх эмийн хэлбэр
6. Эмийн үйлдэл
7. Эм уух ёс
8. Эмийн жорд орж буй түүхий эдүүдийн судалгаа
9. Уламжлалт жорын заалтыг орчин үеийн судалгааны аргуудаар нотолгоожуулах
10. Хэрэглэх заалтыг тайлбарлах

#### **ТОЙРОЛТ 6. МУАУ-НЫ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН НОМХОТГОЛ (8 долоо хоног)**

1. Эмийн түүхий эдийн хоруу чанар багасгах
2. Эмийн түүхий эдийг галыг ашиглан номхотгох
3. Эмийн түүхий эдийг шингэнийг ашиглан номхотгох
4. Эмийн түүхий эдийг гал ба шингэнийг ашиглан номхотгох
5. Эмийн түүхий эдийн хатаах, хагсаах, шатаах, хуурах, шарах технологи
6. Эмийн түүхий эдийг /задгай болон битүү шатаах, шаргаах, хайлуулах, нурамлах/ аргаар номхотгох

#### **ТОЙРОЛТ 7. МУАУ-НЫ ЭМИЙН ТЕХНОЛОГИ (8 долоо хоног)**

1. Тан, талх эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах
2. Үрэл, зуурмал, тосон эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах
3. Үнсэн, өвсөн эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах
4. Хандан, архин эмийг бэлтгэх арга, чанарыг шалгах

#### **ТОЙРОЛТ 8. ЭМНЭЛЗҮЙН ЖОР СУДЛАЛ (10 долоо хоног)**

1. Өвчнүүдийн нөхцөл
2. Өвчин зүйн хувиралт
3. Ангилал, оношилгоо, ялгавартай оношилгоо
4. Эмийн эмчилгээ

#### **ТОЙРОЛТ 9. ГУРВАН ГЭМИЙН ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ (4 долоо хоног)**

1. Өвчнүүдийн нөхцөл
2. Өвчин зүйн хувиралт

3. Ангилал, оношилгоо, ялгавартай оношилгоо
4. Эмийн эмчилгээ

**ТОЙРОЛТ 10. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ДОТОР ӨВЧИН СУДЛАЛ  
(6 долоо хоног)**

1. Өвчнүүдийн нөхцөл
2. Өвчин зүйн хувиралт
3. Ангилал, оношилгоо, ялгавартай оношилгоо
4. Эмийн эмчилгээ

**ТОЙРОЛТ 11. ХАЛУУН ӨВЧИН, МЭДРЭЛ ӨВЧНИЙ ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ (8 долоо хоног)**

1. Өвчнүүдийн нөхцөл
2. Өвчин зүйн хувиралт
3. Ангилал, оношилгоо, ялгавартай оношилгоо
4. Эмийн эмчилгээ

**ТОЙРОЛТ 12. ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХДИЙН ӨВЧНИЙ ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ (8 долоо хоног)**

1. Өвчнүүдийн нөхцөл
2. Өвчин зүйн хувиралт
3. Ангилал, оношилгоо, ялгавартай оношилгоо
4. Эмийн эмчилгээ

**ТОЙРОЛТ 13. ХАМТ ТӨРСӨН НАЙМАН ЯР ШАРХ, ХЭСЭГ БУСАГ ӨВЧНИЙ ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ (2 долоо хоног)**

1. Өвчнүүдийн нөхцөл
2. Өвчин зүйн хувиралт
3. Ангилал, оношилгоо, ялгавартай оношилгоо
4. Эмийн эмчилгээ

**ТОЙРОЛТ 14. ХҮЧЖҮҮЛЭХ, ШИМЖҮҮЛЭХ ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ (2 долоо хоног)**

1. Өвчнүүдийн нөхцөл
2. Өвчин зүйн хувиралт
3. Ангилал, оношилгоо, ялгавартай оношилгоо
4. Эмийн эмчилгээ

## Загвар 1

### Ажлын байрны сургалт (*On-the-Job Training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/ Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг Өдөр бүр	Тасаг	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш
Сургалтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш
Эмийн үйлдвэр, лабораторид ажиллах	3-5	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш
Гардан үйлдэл хийх	Өдөр бүр 3-5	Шаардагдах хугацаагаар	Эмчилгээний өрөө	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш

#### Хяналтын тойрон үзлэг:

Хэвтэн эмчлүүлж байгаа эмчлүүлэгчийн биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг.

Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, эмчлүүлэгчтэй уулзаж асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах, эмийн үйлдвэр болон лабораторид ажиллана. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

#### Сургалтын тойрон үзлэг:

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнийг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ. 1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа өвчтөний орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

## Загвар 2

### Танхимын сургалт (*Off-the-Job Training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Семинар	25 хүртэл	7 хоногт 2-3 удаа 90 минут	Сургалтын анги, танхим	Зонхилон тохиолдох өвчний	Эмнэлзүйн сургагч багш, хамтран



				сэдвүүдээр PPT, карт	суралцагч эмч
<b>Бие даалт: Эмнэлзүй, онолоор</b>	1	Тохиромжтой чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернэт	Өөрөө, хамтран суралцагч эмч
<b>Лекц</b>	25 хүртэл	7 хоногт 2-3 удаа 90 минут	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
<b>Журнал клуб</b>	25 хүртэл	7 хоногт 1 удаа 60 минут	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэлзүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
<b>Симуляци (дуураймал орчин)</b>	5 хүртэл	7 хоногт 1 удаа 60 минут	Ур чадварын өрөө, яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч, манекен	Эмнэлзүйн сургагч багш
<b>Эмийн үйлдвэр, лабораторид ажиллах</b>	5 хүртэл	7 хоногт 1 удаа 60 минут	Эмийн үйлдвэр, лаборатори	Хамтран суралцагч	Эмнэлзүйн сургагч багш
<b>Дүрд тоглох</b>	5 хүртэл	7 хоногт 1 удаа 60 минут	Ур чадварын өрөө, яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч	Эмнэлзүйн сургагч багш

### Загвар 3

#### Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
~8:00	Эмийн үйлдвэрт ажиллах	Ганцаарчилсан үзлэг	Эмийн үйлдвэрт ажиллах	Ганцаарчилсан үзлэг	Лабораторид ажиллах
8:00-9:00	Эмийн үйлдвэрт ажиллах	Хяналтын тойрон үзлэг	Эмийн үйлдвэрт ажиллах	Хяналтын тойрон үзлэг	Лабораторид ажиллах
9:00-	Эмийн үйлдвэрт ажиллах	Бие даалт	Эмийн үйлдвэрт ажиллах	Бие даалт	Лабораторид ажиллах
12:00-13:00	Бие даалт	Лекц, семинар	Бие даалт	Лекц, семинар	Журнал клуб
16:00-17:00	Сургалтын тойрон үзлэг	Бие даалт	Сургалтын тойрон үзлэг	Бие даалт	Бие даалт

## ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

### 7.1 Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрд хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн ((mentor) цаашид "хариуцагч" гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

### 7.2 Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрд сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.
- Сургагч багш нь Анагаах ухааны магистр, доктор, дэд профессор, профессор цол зэргээс доошгүй зэрэгтэй, багшлах эрх бүхий, сурган заах арга зүйн албан ёсны сургалтад хамрагдсан байна.
- Сургагч багш нь мэргэжлийн ахлах, тэргүүлэх зэрэгтэй эмч, 10-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, дадлага туршлагатай, сурган заах арга зүйн албан ёсны сургалтад хамрагдсан байна.
- Элсэгч нь Анагаах ухааны их, дээд сургуулийг УАУ-ны хүний их эмчийн мэргэжлээр төгссөн, бакалаврын зэрэгтэй байна.

### 7.3 Үнэлгээний арга

#### 7.3.1 Төгсөлтийн шалгалт

"Монгол эм судлал"-ын сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд "Монгол эм судлаач эмч"-ийн үнэмлэх олгоно.

#### 7.3.2 Ажлын байранд суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

##### 360 хэмийн үнэлгээ (*360-Degree Assessment*):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон

хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

**Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (*Mini-Clinical Evaluation Exercise*):**

Зайлшгүй таньж мэдэх 25 шинж тэмдгээс тойролт бүрд 5-аас доошгүй шинж тэмдгийг түс бүр 3-аас доошгүй удаа, нийт 15-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтод ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно. (Жишээ нь: Үндсэн зургаан өвчний тойролтод хэвлийгээр өвдөх шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол дотор өвчин, эс шингэсэн өвчний тойролтод ч хэвлийгээр өвдөх шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийж болно).

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

**Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт / DOPS (*Direct Observation of Procedural Skills*):**

Зайлшгүй сурах 65 гардан үйлдлээс 45-аас доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ. Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

**Портфолио үнэлгээ (*Portfolio Assessment*):**

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, уламжлалт анагаахын тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

**7.4 Үнэлгээний дүнг хянах**

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн бусад асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-сех болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

## 7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Тойролт бүрд хийгдсэн Mini-сех болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini-сех болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийг эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:
  - Зайлшгүй таньж мэдэх 25 шинж тэмдгээс 2 жилийн турш 22-оос доошгүйг оношилж, эмийн эмчилгээг төлөвлөх туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь :
    - \* Тойролт бүрд заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
    - \* Зайлшгүй суралцах 65 гардан үйлдлээс 2 жилийн турш 45-аас доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

## Найм. Хэрэгжүүлэлт

### (Хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)

#### 8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалтын албаны мэргэжилтэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын дэд дарга, амбулатори - уламжлалт эмчилгээний тасгийн хариуцагч, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь сар бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

#### 8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт 5 жил тутамд үнэлгээ хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (Faculty Development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.

#### 8.3 Сургалтын танилцуулга(Orientation)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Program) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх

байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, эмнэлгийн эрхзүйн тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

## 360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_

Үнэлгээ хийгч:  Эмнэл зүйн сургагч багш  Сувилагч  Бусад \_\_\_\_\_

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор (≤19)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд (≥80%)

Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэт, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачилгаар хувь нэмрээ оруулдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахад хичээн зүтгэл гаргадаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэж эмчилдэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн уламжлалт анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутаг дахь бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: "Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?"

## ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он,сар, өдөр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_

Үнэлэгчийн нэр: \_\_\_\_\_

Сургалт эрхлэх байгууллага: \_\_\_\_\_ Нэгж: \_\_\_\_\_ Газар:  Амбулатори  
 Эмийн үйлдвэр  УА тасаг  Бусад \_\_\_\_\_ Өвчтөний нас: \_\_\_\_\_ Хүйс:  Эр  Эм

Өвчтөний зовуурь:  Халуурах  Шарлах  Толгой өвдөх  Ухаан санааны байдал өөрчлөгдөх  Татах  Ханиалгах  Цээжээр өвдөх  Дотор муухайрах, бөөлжих, Хоосон огих  Хэвлийгээр өвдөх  Суулгах  Нуруу өвдөх  Саажих  Хавагнах  Үе өвдөх  Зүрх зогсох  Жихүүцэх  Эвшээх, суниах  Таван мэдрэхүй үл тодрох  Сэтгэл санаа тогтворгүй болох  Сүүж бэлхүүс, яс үесээр хатгуулж өвдөх  Энд тэндгүй тогтворгүй өвдөх  Идээ шингэсний дараа, өглөө үүрээр, үдшийн бүрийд өвчин хөдлөх  Аманд гашуун амт амтагдах  Идээ шингэх үед өвдөх  Хоолонд дургүй болох  Бусад \_\_\_\_\_

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.

Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх авах			
Бодит үзлэг			
Оношилгоо, эмчилгээний менежмент			
Харилцааны ур чадвар			
Эмнэл зүйн ерөнхий чадвар			

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

Үнэлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ Суралцагч эмчийн гарын үсэг \_\_\_\_\_

"Хангалттай" гэж тодорхойлоход хэрэглэх үзүүлэлт

Өвчний түүх авах	<ul style="list-style-type: none"> <li>• ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг</li> <li>• өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг.</li> <li>• өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг.</li> </ul>
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> <li>• ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг.</li> <li>• үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг.</li> </ul>
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none"> <li>• зөв онош тавьдаг</li> <li>• оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• тохирсон эмчилгээг эхлүүлдэг.</li> <li>• тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.</li> </ul>
Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл садны хүнийг сайн сонсдог.</li> <li>• өвчтөн, түүний гэр бүл, амран хамгаалагч, төрөл садны хүнтэй эелдэг энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг</li> <li>• өвчтөн, түүний гэр бүл, амран хамгаалагч, төрөл садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг.</li> </ul>
Эмнэл зүйн ерөнхий чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог.</li> <li>• өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвх зүтгэл гаргадаг</li> <li>• би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна!</li> </ul>



### ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭ

Он, сар, өдөр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_

Үнэлэгчийн нэр: \_\_\_\_\_

Сургалт эрхлэх байгууллага: \_\_\_\_\_ Нэгж: \_\_\_\_\_ Газар:  Амбулатори

Эмийн үйлдвэр  УА тасаг  Бусад \_\_\_\_\_

**Гардан үйлдэл:**  Амилуулах суурь тусламж, зүрх уушгины сэхээн амьдруулалт  Тариа хийх (судас тариа, булчин тариа, арьсан дор)  Зүрхний цахилгаан бичлэг хийх  Цусан дахь сахарын хэмжээг тодорхойлох  Ханах заслын холын бэлтгэл хийх  Ханах заслын ойрын бэлтгэл хийх  Хануурын боолт хийх  Ханах засал хийх  Уул өвсөн төөнө хийх  Харандаан төөнө хийх  Эмч бодисын төөнө хийх (Монгол төөнө)  Зүүлэх төөнө засал хийх  Хайрцган төөнө хийх  Шовгон төөнө хийх  Хатгуур засал хийх  Бүлээн зүү засал хийх  Сам соруул засал хийх  Соруул засал хийх  Шивүүр засал хийх  Усан дэвтээлэг засал хийх  Ороож боох дэвтээлэг хийх  Илж нухлах засал хийх  Шимжүүлэх бариа хийх  Жин засал хийх

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо \_\_\_\_\_

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг. Өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гарлан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэт бичдэг.				
<b>Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар</b>				

Зөвлөмж:

- Сайн тал:
- Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлэгчийн гарын үсэг: \_\_\_\_\_

Суралцагч эмчийн гарын үсэг: \_\_\_\_\_

## НОМ ЗҮЙ

1. Д.Цэнд-Аюуш, Т.Алимаа, Ч.Батнайрамдал ...нар "Монгол анагаах ухааны онол" "Мөнхийн үсэг" ХХК. 2017 он
2. Х.Тумбаа "Анагаах ухааны дөрвөн үндэс"(хөрвүүлсэн) Улаанбаатар 1991
3. Ютиг Ёндонгомбо "Сориг жүд ши" Монгол хадмал хэвлэл, Өвөр Монголын үндэстний хэвлэлийн хороо, I,II боть.Хөх хот 1991 он
4. Ч.Батнайрамдал "Төвөд хэл сурах бичиг" Бит трейд, 2016
5. У. Лигаа. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорны анагаах ухаанд хэрэглэхүй. УБ. 2005.
6. Б.Дагвацэрэн. Г.Наранцэцэг. Ургамлын эмийн зохистой хэрэглээний гарын авлага. УБ. 2005.
7. Б. Хүрэлчулуун, Д. Суран. Монгол эмэнд хэрэглэдэг ургамлын түүхий эдийн зурагт лавлах . УБ.2007.
8. Б. Хүрэлчулуун, Ө. Батчимэг. Монгол орны ургамлын гаралтай зарим эмийн түүхий эдийн лавламж. УБ. 2006.
9. Б.Хүрэлчулуун, Ө.Батчимэг. Монгол эмэнд хэрэглэгддэг гадаад ургамлын түүхий эд. УБ.2004
10. Б. Пүрэвсүрэн, З. Мэндсайхан. Монгол эмийн эрдэс чулуу. УБ. 2002.
11. Ц. Хайдав, Ц. Ширхан. Монгол ардын эмнэлэгт хэрэглэгдэж байсан зарим эрдэс. УБ. 1975.
12. Ц. Хайдав. Ардын эмнэлэгт хэрэглэгддэг амьтны гаралтай эм. I, II боть. УБ. 1977-1982.
13. Ч. Баавгай, Б. Болдсайхан. Монголын Уламжлалт Анагаах Ухаан. УБ. 1980.
14. Олдох С. Цэрэнцоо Б. Батхуяг П. "Монгол эмийн судлал" УБ 2017
15. Ганбаяр Я. "Монгол эмийн жорын гарын авлага". УБ. 2001
16. Дэсрид Санжаажамц " Манаглхантав" Төвөд, Уйгаржин, Хөх хот 1992, Үндэсний хэвлэлийн хороо, х 163-195
17. Дарма маарамба Лувсан чойрог "Алтанчимэг" Хөх хот, Ардын хэвлэлийн хороо 1988, х256-299
18. Чоймбол тойн. Жүдүйниннор, Хөх хот 1999, Ардын хэвлэлийн хороо х77-81
19. Б.Болдсайхан " Буддын сургаал ба шинжлэх ухаан" УБ.2003 он, х382-395
20. Дарма маарамба Лувсанчойрог " Алтан хадмал" Хөх хот, доод дэвтэр, 1984, Ардын хэвлэлийн хороо, х1110-1128
21. С.Сээсрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг "Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увдис" УБ 2016, х 47-51
22. С.Сээсрэгдорж "Тэжээхүйн ухаан дахь эрүүл аж төрөх их өв соёл" УБ.2012
23. Сүрэнжав Ч. "Монгол анагаах ухааны эм найрлагын судлал". Хөх хот 1986
24. Лувсан Б. "Монгол эм судлал". Хөх хот. 1988
25. Төмөрбаатар Н, Хатанбаатар Ж, Цэрэндагва Д, "Уламжлалт анагаахын суурь мэдлэг" УБ 2006.
26. Дагвацэрэн Б нар. Уламжлалт эмийн жорын хяналтын лавламж. Улаанбаатар. 2015
27. "Монгол эмийн материалын баримжаа" Хөх хот 1999
28. Лувсанчоймбол. "Тус амгалангийн шимийн хураангуй "
29. Чойжамц. "Маш гайхамшигт хуримын сан". Төвд хэлнээс орчуулсан Д. Балгансүрэн. УБ 1994.
30. Данзанпунцог. Эмийн хиргүй болор эрхи. ӨМӨЗО-ны Шинжлэх ухааны техник мэргэжлийн хэвлэлийн хороо. Улаан хал хот. 2001
31. Лувсанчүлтэм. Эм таних ухаан. Үндэсний хэвлэлийн хороо. 1998

32. М.Биндэрьяа, М.Бөхчулуу, А.Гарамжав. Эмийн ургамлаас биологийн идэвхт бодисууд ялгах аргачлал. Тоонот принт. Улаанбаатар. 2016
33. З.Мэндсайхан, З.Ариунаа, М.Пүрэвжав. Эмт ургамал. Нэпко паблишинг. Улаанбаатар. 2016.
34. Д.Цэнд-Аюуш нар. “Лекарственные растения Монгольской Традиционной медицины” 2021
35. Tsend-Ayush D et al. “Drug Discovery in Traditional Mongolian Medicine” 2021